

## **ХЯТАДЫН ӨМӨЗО-Ы ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨГЖИЛТИЙН ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ**

*Н. Улаан-Од\**

ӨМӨЗО нь Хятадын хойт хил хэсэгт байршиж, Хар мөрөн, Гирин, Ляонин, Хэбэй, Шаньши, Ниншя, Ганьсу зэрэг мужуудтай хиллэж, Орос, Монгол хоёр улстай хөршлөж байдаг. 1.183 сая км<sup>2</sup> газар нутагтай бөгөөд бүх улсын нийт талбайн 12.3 хувийг эзэлж, гуравдугаар байрт ордог. ӨЗО нь 7 хот, 5 аймаг, 101 хошуу шянь, хот, дүүрэгтэй, монгол, хятад, манж, хотон зэрэг 49 үндэстэнтэй, нийт хүн ам нь 23.775 сая, үүнээс хөдөөгийн хүн ам нь 13.8 сая болно.

### **Нэг. ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОЙМ БАЙДАЛ**

Наяад оны эхнээс нааш, манай орон эн тэргүүнд гэр бүлийн даачлалтын дүрмийг хэрэгжүүлж, ерээд оноос хойш их хэмжээгээр хөдөө аж ахуйн бүтцийг тохируулснаас уг салбр нь цоо шинэ хөгжилтийн үедээ орж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн мэдэгдэм өсөж, чанар чансаа нь улам дээшилж, зах зээлд өрсөлдөх чадвар нь тасралтгүй эрчимжжээ.

1. Амуу будааны үйлдвэрлэлт Манай орны амуу будааны төрөлд эрдэнэ шиш, буудай, усан тутарга, буурцаг, төмс зэрэг таван том төрөл ордгоос гадна нарим, шиш, юу май, ногоон буурцаг зэрэг төрөл бүрийн буурцагт таримал ордог. Сүүлийн жилүүдэд адил бус газар орны онцлог болон давуу талыг бадруулсан амуу будааны баазыг үндсэндээ буй болгов. Жишээлбэл: Бортохойн тал газрын, Түмдийн тал газрын охь шилдэг буудайн үйлдвэрлэлийн бааз, баруун Ляохэгийн тал газрын охь шилдэг эрдэнэ шишийн үйлдвэрлэлийн бааз, Их хянган давааны зүүн өмнөх охь шилдэг буурцаг, буудайн үйлдвэрлэлийн бааз, дунд болон баруун хэсгийн довлог, ган хуурайн бүсийн охь шилдэг төмс, төрөл бүрийн амуу будаа буурцгийн үйлдвэрлэлийн баазууд хамрагдаж байна.

Одоо манай орны амуу будааны үйлдвэрлэл нь яг өнгөрсний дан ганц тоон үзүүлэлтийг гол хөөцөлддөг байснаасаа өндөр ургац, шилдэг чанар, дээд үр ашгийг хослуулсан шат уруу шилжиж байна. 1990 оноос хойш, амуу будааны тарих талбай нь үндсэндээ 4 сая га талбай болжээ. 1992 оноос хойш амуу будааны нийт ургацын хэмжээ 10 сая тоннд хүрчээ. Хамгийн өндөр ургац хураасан 1998 онд 16 сая тоннд хүрчээ. Хүн бүрд дунджаар 600 кг амуу будаа ногдох болж, бүх улсын хэмжээнд гуравдугаар байр эзэлж байна.

\*Н.Улаан-Од - Өвөр Монголын их сургууль

2. Тослог ургамлын үйлдвэрлэлт Манай орны тослог ургамлын үйлдвэрлэл нь наран цэцгийн үр, юусай, хумаа зэргээр голлож байна. Бүх орны дийлэнхи аймаг хот бараг цөм эдгээр тослог ургамлыг тарьж байдаг. 1990 оноос нааш тарих талбай нь бараг 500 га талбайгаас давж, ургац нь 650 мянган тонноос дээш байна. 2000 онд 8 сая га талбайгаас 116 тонн ургац авсан нь хамгийн өндөр үзүүлэлт байв. 2000 онд хүнсэнд хэрэглэх тос бүрд дунджаар 49 кг-д хүрч, бүх улсын хэмжээнд тэргүүн байрт орсон байна.

3. Чихэрлэг ургамлын үйлдвэрлэлт Манай орон 1955 оноос эхлэн чихэрлэг ургамлыг тарьж эхэлснээс нааш сүүлийн хэдэн арван жилд эрчтэй хөгжиж ирсэн байна. 1991 оноос хойш тарих талбай нь 100 мянган гектороос дээш болж, ургац нь 2.3 сая тонноос давсан байна. Гэвч 1999 оноос хойш олон улсын зах зээлийн нөлөөнөөс шалтгаалж, чихэрлэг ургамлын ургацын хэмжээ доошилсон байна. 2000 онд хүн бүрд ногдох чихэрлэг ургамлын хэмжээ нь 60 кг байж, улсын хэмжээнд долдугаар байр эзэлсэн байна.

4. Гуа жимс ногооны үйлдвэрлэлт 1. Гуаны төрөлд: шийгуа, балт гуа, үрт гуа хамрагддаг. Сүүлийн жилүүдэд таримлын бүтцийг тасралтгүй зохицуулахыг дагалдан тарих талбай нь жил дараалан нэмэгдэж, ургац болон эдийн засгийн үр ашиг ихээр дээшилжээ. 2000 оны тарих талбай, нийт ургац нь тус бүр 48 мянган гектор буюу 11 сая тоннд хүрэв.

2. Манай орны жимсний мод тарьж ирсэн түүх богино боловч сүүлийн жилдүүдэд хөгжилт нь түргэн болж иржээ. Үүнд голдуу алим, усан үзэм, алимны мод орж байна. 2000 онд жимсний мод тарих талбай нь 76 мянган га, нийт ургац нь 220 мянган тн-д хүрчээ.

3. Сүүлийн жилүүдэд иргэдийн амьдралын түвшний дээшлэлт, таримлын бүтцийн зохицуулалтын үрээр, манай орны хүнсний ногооны тариалалт ихээр дээшилжээ. Нэн ялангуяа өндөр үр ашигт, өндөр ургац нь тариачдын талархлыг хүлээж байна. Зах зээлийг элбэгжүүлж, шаардлагыг хангаж, тариачны орлогыг дээшлүүлэх тал дээр тун их хувь нэмэр оруулсан байна. 2001 онд хүнсний ногооны талбай 182 мянган га, нийт ургацын хэмжээ 8 сая тоннд хүрчээ.

### **Хоёр. ХӨДӨӨ АЖ АХУЙН НӨӨЦ**

1. Нарны тусгал Бүх оронд нарны тусгал сайн байдаг тул 4-9 сарын хоорондох үр тариа нь бойжилтын үед нарны тусгалыг 70%-иар хүлээн авч чаддаг.

2. Дулааны энерги Бүх орны дулааны энергийн баялаг маш элбэг тул таримлын ургалтын үед дундаж дулааны хэмжээ нь 2-8 c,  $\geq 10$ , c градус байж, 120-160 өдөр үргэлжилдэг.

3. Усны нөөц Бүх орны усны нөөц 50.9 тэрбум м.куб байж, бүх улсын хүн бүрд тэгшитгэсэн хэмжээний 85 хувийг эзэлдэг. Хур тундасын хэмжээ 50-450 мм хүрдэг тул таримлын аж ахуйг хөгжүүлэхэд нэлээд ашигтай юм.

4. Тариалах талбай Бүх орны тариалах талбай 7.52 сая га, үүнд усжуулалттай талбай 2.53 сая га-д хүрч, хүн бүрд ногдох тарих талбай 0.32 га байж, бүх улсад тэргүүн байр эзэлнэ. Тариалангийн талбай нь голдуу Бортохойн сав газар, Түмдийн сав газар, Баруун Ляохэгийн сав газар болно.

5. Төрөл зүйлийн эх баялаг Манай орны таримлын төрөл зүйл нь ч маш элбэг баялаг байдаг. Бүх оронд амуу будаа, тослог ургамлын 25 зүйлийн 10 мянган төрлийн хүнсний тарималтай юм. Зарим бохирдолгүй таримлын төрөл нь гадаад дотоодод нэлээд нэр хүндтэй юм.

### **Гурав. АШИГГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД**

1. Байгалийн гамшиг Манай орон нь байгалийн гамшигт нэлээд өртдөг орны нэг юм. Үүнд голдуу өвлийн цас зуд, хаврын элсэн шуурга, зуны үер усны гамшиг гэх мэтчилэн.

2. Усны нөөцийн тархалт тэгшгүй Манай орон хүн бүрд тэгшитгэсэн усны нөөц бүх улсад нэлээд дээгүүр ордог боловч, нэг гектор тарих талбайд усжуулах хэмжээ нь бүх улсын дундаж хэмжээний гуравны нэгд ч хүрэхгүй байна.

3. Уулархаг довлог газар олон Бүх орны нийт талбайн 27 хувь уулархаг, 44 хувь довлог, 19 хувийг элсэрхэг нутаг эзэлж, бүх тарих талбайн гуравны хоёрыг ган хуурай тарих талбай эзэлж, тогтмол бус усжуулах талбай нь гуравны нэгт л хүрч байна.

4. Хөдөө аж ахуйн техник мэргэжлийн түвшин доор 2000 онд бүх оронд тариалангийн машин техникийн хөдөлгөх хүч 13.50 сая киловатт байж, нэг га талбайд дунджаар 1.8 квт тусч, бүх улсын нийт хэмжээний 44.6 хувьд л хүрч байна. Бүрх орны 10 мянган хүн тутам 16 хөдөө аж ахуйн мэргэжилтэн ногдож, бүх улсын түвшнээс нэлээд доогуур орж байна.

### **Дөрөв. МАЛ АЖ АХУЙ**

Өвөр монголын мал аж ахуй нь манай улсын маш чухал салбар юм. Манай орны мал аж ахуйн нутаг бэлчээрийн нийт талбай нь 1.32

тэрбум мү-д хүрч, бүх орны нийт талбайн 75 хувийг эзэлж, үүнд ашиглаж болох нутаг бэлчээр нь 1.02 тэрбум мү-д хүрчээ. Өвөр монголын нутаг бэлчээрий тал бэлчээрийн, тачир бэлчээрийн, элсэрхэг бэлчээрийн гэж хэдэн бүлэгт хуваадаг бөгөөд 793 төрлийн өвс ургамалтай юм.

Манай орон мал сүргийн эх баялаг ихтэй. Нутаг бэлчээрийн нөхцөл байдлаас болж, мал сүргийн олон үүлдрийг буй болгожээ. Үүнд монгол адуу, монгол үхэр, монгол хонь, монгол тэмээ болон ноолуурын цагаан ямааны үүлдрийг буй болгосноор барахгүй сань хэ морь, талын улаан үхэр, өвөр монголын нарийн ноост хонь, өвөр монголын цагаан ноолуурт ямаа, алашагийн хос бөхт тэмээ, улаанхалын гахай зэрэг 25 төрлийн шилмэл үүлдэр байна.

ӨМӨЗО-ны мал аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт

/Хүснэгт 1/

№	Бүтээгдэхүүний нэр	2001 он	1981 он өсөлт /дахин/	Өсөлт жилийн дундаж %
1	Махан бүтээгдэхүүн	1,50 сая.тн	6,2 дахин	9%
2	Тахианы өндөг	264 мян.тн	6,4 дахин	10%
3	Үнээний сүү	1,09 сая.тн	14,1 дахин	13%
4	Хонины ноос	610 мян.тн	0,9 дахин	3%
5	Ямааны ноолуур	3999 тн	2,3 дахин	5,6%

Бүх орны мал аж ахуйн нийт бүтээгдэхүүний хэмжээ 11,8 тэрбум юаньд /1990 оны үнээр/ хүрч, бүх орны тариалан, мал аж ахуй, загасны аж ахуйн нийт бүтээгдэхүүний 39 хувийг эзэлж, хорин жилийн өмнөөс 3 дахин, жилд дунджаар 7,2% нэмэгджээ, малчдын цэвэр орлого 3277 юаньд хүрч, хорин жилийн өмнөөс 16,4%, жилд дунджаар 13,9% нэмэгдлээ.

ӨМӨЗО-ны мал аж ахуйн бүтээгдэхүүний гаралтыг

бүх хятадын хэмжээнд харьцуулбал:

/Хүснэгт 2/

№	Нэр	2001 онд /хувиар/	Байр
1	Хонь ямааны мах	10%	IV
2	Үүнээс хонины мах	17,4%	II
3	Үнээний сүүл	10,2%	III
4	Хонины ноос	19,5%	II
5	Ямааны ноолуур	34,2%	I

Манай орны мал аж ахуйн бүтээгдэхүүний хүн бүрт ногдох хэмжээ нь 63 кг-д хүрч, бүх улсын хүн бүрт ногдох хэмжээнээс 8,7 кг-аар илүү, хүн бүрт ногдох цагаан идээ 45,9 кг-д хүрч, бүх улсын хүн бүрт ногдох хэмжээнээс 5,2 дахинаар илүү байна, малчдын цэвэр орлого онь ч бас бүх улсын тариачдын хүн бүрт ногдох цэвэр орлогоос давжээ.

1999 оноос эхлэн гурван жил дараалан манай орон байгалийн янз бүрийн гамшигт учирсан боловч, мал аж ахуйн салбар тогтвортой хөгжиж иржээ. Үүнээс гадна мал аж ахуйн бусад салбар ч нэлээд амжилт олсон байна. Үүнд:

1. Нутаг бэлчээрийн экологи, байгаль хамгаалалтын ажил ч урагштай явагджээ. Энэхүү ажлыг үр өгөөжтэй хийснээс малчдын нутаг бэлчээрээ бүтээн байгуулах, хамгаалах идэвхжил дээшлэн, элсийг тогтворжуулан өвс мод тарьж, малыг хашаалан малласнаас 2001 онд 60,68 сая мүн нутаг бэлчээрийг бүтээн байгуулж, үүнд хүний хүчээр 12,27 сая мүн талбайд тарьж, 26,59 мүн бэлчээрийг торлон битүүмжилсэн байна.

2. Нутаг бэлчээрийн даацыг үндэслэн мал сүргийн тоо толгойг тогтоосноос манай орны 4 хошуу, 36 суманд нутаг бэлчээрийн даац болон мал сүргийн толгойг тэнцүүржүүлэх туршилт хийж нэлээд туршлага хуримтлуулсан байна.

3. Үржлийн малын үүлдрийг сайжруулав. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлт, үр ашгийг тасралтгүй дээшлүүлж ирснээс 2001 онд манай орны сайн үүлдрийн үрийн мал 47,1 сая толгойд хүрч, өмнөх жилээс 1,9 сая толгойгоор өсөж, үүлдэр сайжруулсан хэмжээ нь 77%-д хүрч, үрийн малыг үндсэндээ сайн үүлдрийн малаар орлуулсан байна.

4. Мал сүргийн бүтцийг зүй зохистой тохируулснаас эх малын харьцаа 53 хувьд хүрч, хорогдол багатай, өсөлт нь түргэн, арчлах хугацаа нь богино, таваарын ашиг өндөр байх зорилтыг биелүүлснээр малчдын орлого мэдэгдэм дээшлэв. “Өвөр Монголын нарийн ноост ямааны ноолуурын бүтээгдэхүүний яармаг худалдаа”-г хэд хэдэн удаа амжилттай зохион байгууллаа.

5. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хүчин чадал тасралтгүй дээшилснээс, 2000 онд манай орны махан бүтээгдэхүүний хэмжээ 10 мянган тонноос давсан хошуу шянь 57 байж, бүх орны нийт хэмжээний 90 хувийг эзэлж, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 10

мянган тонноос давсан хошуу шянь 22 байж, бүх орны нийт хэмжээний 78 хувийг эзэлж, хонины ноосны хэмжээ 1000 тонноос давсан хошуу шянь 23 байж, бүх орны нийт хэмжээний 57 хувийг эзэлж, ямаа ноолуурын хэмжээ 50 тонноос давсан хошуу шянь 25 байж бүх орны нийт хэмжээний 78 хувийг эзэлжээ. Өмнөх жилтэй харьцуулбал манай орны мал аж ахуйн салбарын хүрээ хэмжээ, чанар чансаа мэдэгдэм дээшилсэн байна.

6. Мал аж ахуйн таваарын бүтээгдэхүүний бааз буй болсноос нааш, И ли, Шин фа, Мэн Нэюү, Ордос, Ши чи зэрэг групп компаниуд манай орны мал аж ахуйн эх баялагт суурилан, барааны нэр шошгийг үүдэн бүтээж, эдийн засгийн үр ашгийг дээд хэмжээнд хүргэж, эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлж байна.

7. Малын өвчнөөс сэргийлэх ажлын талаар нэлээд амжилт олжээ. 2001 оны байдлаар 20 сая толгой сүрэгт урьдчилан сэргийлэх янз бүрийн тариа хийсэн байна. Одоогоор 92 хошуу шянь, 370 шян балгасанд “Тогтмол цэгт нядлах, төвлөрсөн байдлаар тариа хийх” арга хэмжээ авснаар манай оронд сүүлийн жилд малын онцгой өвчин хижиг дэлгэрсэнгүй.

Манай орны мал аж ахуйн салбарт хойшид авах арга хэмжээнүүд гэвэл:

1. Төрийн зөвлөлөөс тогтоосон “Мал аж ахуйн хөгжилтийг түргэтгэх санал”-ыг хэрэгжүүлэх.

2. Нутаг бэлчээрийг хувь өрхөд хариуцуулах бодлогыг тууштай явуулах.

3. Мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөтлөх хуучин арга хэлбэрийг өөрчлөх.

4. Нутаг бэлчээрийн экологийн байдал үржлийн мал сүргийн бүтцийг сайжруулах.

5. Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

6. Тариалах оронд мал аж ахуйг хөгжүүлж, тариачдын орлогыг дээшлүүлэх.

7. Шинжлэх ухаанчаар мал аж ахуйг эрхэлж, малчдын орчин үеийн арга барилаар мал маллах мэдлэг боловсролыг нь шинэчлэх.

8. Мал сүргийг янз бүрийн өвчинөөс урьдчилан сэргийлж, хөрш зэргэлдээ улс оронтой нягт хамтран ажиллах зэрэг болно.